



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/424

Булган сум

┌ Аймгийн аялал жуулчлалын аппликейшнийг ┐
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.9, 23.1.11 дэх заалт, Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 278 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.10.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аялал жуулчлалын “Bulgan-Trip” аппликейшнийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Насанжаргал (Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

- Э.Эрболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
- Э.Эрдэнэжаргал (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
- Б.Нямсүрэн (Аймгийн Засаг даргын тамгын газрын мэдээллийн технологийн ажилтан)
- Г.Лхагвадаш (Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Төлөвлөлт, тайлагналт, цахимжилт хариуцсан ахлах мэргэжилтэн)
- Э.Мөнх-Очир (Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн Мэдээллийн технологийн багш)

Нарийн бичгийн дарга: Г.Алдармөнх (Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

2. Аялал жуулчлалын аппликейшний техникийн үзүүлэлт, чанарын баталгаанд хяналт тавьж, өгөгдсөн ажлын даалгаврын дагуу хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Насанжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010563